

Авто замын ажлын ТББ

## БАТЛАВ:

# ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

## ОРХОН АЙМГИЙН ЗДТГ

Огноо: 2020.06.11

## АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: Дэнж багийн 20-р цэцэрлэгийн арын сайжруулсан шороон замын засвар

Төслийн дугаар: ОР-55/2020

## Эрдэнэт хот

2020 OH

## НЭГ.ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020.06.11

Тендер шалгаруулалтын нэр: Дэнж багийн 20-р цэцэрлэгийн арын сайжруулсан шороон замын засвар

Тендер шалгаруулалтын дугаар: ОР-55/2020

Орхон аймгийн ЗДТГ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогдоос "Дэнж багийн 20-р цэцэрлэгийн арын сайжруулсан шороон замын засвар" ажлыг гүйцэтгэх тухай цахим үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа хялбаршуулсан цахим тендер тул ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50000 (Тавин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд нийцүүлэн тендерийн баримт бичигт тодорхойлсон журам болон Харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгоно.

Үнийн саналын баримт бичигт зураг, төсөв, техникийн тодорхойлолт, тавих шаардлагыг хавсаргасан болно.

Энэ урилгад заагдаагүй бусад нөхцөлийг тендерийн баримт бичигт тусгасан болно

Тендерийг **2020 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн 08 цаг 30 минутаас** өмнө төрийн худалдан авах ажиллагааны цахим [/www.tender.gov.mn/](http://www.tender.gov.mn/) системд илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн 09 цаг 00 минутанд** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**[Орхон аймаг ЗДТГ 113 тоот, Орон нутгийн өмчийн газар 70358570]**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |  |   |
|--|---|
| <p><b>1. Эрх бүхий тендерт оролцогч</b></p>      | <p>1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</p>  |
| <p><b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b></p> | <p>2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</p> <p>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.</p> <p>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</p>   |
| <p><b>3. Тендерийн иж бүрдэл</b></p>             | <p>Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:</p> <p>1. Унийн санал /маягтаар/ ирүүлэх.<br/>2. Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь ирүүлэх.<br/>3. Ажил гүйцэтгэх хуваарь ирүүлэх.<br/>4. Улсын бүртгэлийн гэрчилгээ эх хувиас ирүүлэх.<br/>5. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрээ, хавсралтыг эх хувиас ирүүлэх.<br/>6. Тендерт оролцогчийг төлөөлж итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурах бол төлөөлөгч этгээдийн итгэмжлэл, итгэмжлэгчийн иргэний үнэмлэхийг эх хувиас ирүүлэх<br/>7. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендерт оролцогчийн татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар шалгах тул өр, төлбөргүй байх шаардлагатай.<br/>8. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтын цахим тодорхойлолтыг ТҮЦ машинаас авч эх хувиас ирүүлэх.<br/>/Тендер нээсэн өдрөөр өр төлбөргүй байна./<br/>9. Шүүх байгууллагын тодорхойлт<br/>10. Харилцагч банкуудаас зээлтэй эсэх талаар тодорхойлолтыг ирүүлэх.</p> |

Авто замын ажлын ТББ

11. Гэрээний өрөнхий болон тусгай нөхцөлийг зөвшөөрч байгаа эсэх талаарх мэдэгдэлийг ирүүлэх.
12. Тендерт оролцогч нь (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) уг ажлын зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээг хянах этгээдтэй нэгдмэл сонирхолтой эсэх талаар мэдэгдэлийг эх хувиар ирүүлнэ.
13. Татвар, Нийгмийн даатгал, шүүх, ШШГГ, харилцагч банк болон бусад байгуулагуудаас тендертэй холбоотой асуудлаар тодруулага авахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдэлийг эх хувиас ирүүлэх.
14. Шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын зураг, техникийн тодорхайлолтын дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж ашиглалтанд хүлээлгэн өгөх тухай баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.
15. Ижил төстэй ажил иус бүрийн гүйцэтгэл, чанар байдлын тодорхайлолтыг ашиглагч болон захиалагч байгууллагаас тус тус ирүүлэх.
16. Санхүүгийн тайланг тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн [www.e-balance.mof.gov.mn](http://www.e-balance.mof.gov.mn)-ээс тендерт оролцогчдын татвар төлөлт, санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллүүдийг шалгана.
17. Тендерт оролцогч нь ажлыг богино хугацаанд чанартай гүйцэтгэх ИТАжилтан, мэргэжлийн ажилтан, ажилчдын нотлох баримтыг ирүүлнэ. Үүнд:  
-Инженер, техникийн ажилтнууд, мэргэжлийн ажилтан, ажилчдын чадавхийн мэдээлэлийг ирүүлэх ба диплом, мэргэжлийн үнэмлэхийг эх хувиас ирүүлэх.
18. ИТА –үүд нь үндсэн ажилтнууд байх ба сүулийн 3 сарын НД-8 маягтыг эх хувиас ирүүлэх.
19. Машин, техник тоног төхөөрөмжийн чадавхийн мэдээлэлийг ирүүлэх./гэрчилгээ хавсаргаж ирүүлэх/
20. Ажлын тоо хэмжээ бүрэн тооцсон төсөө ирүүлэх (эрх бүхий төсөөвчнөөр хийлгэж баталгаажуулсан байх)
21. Тухайн ажилд ашиглагдах бараа материалын сертификат, гарал үүслийн гэрчилгээг ирүүлэх.
22. Тендерийн бичиг баримтны гадаад хэл дээрх материалын баталгаат орчуулга хийж ирүүлэнэ.
23. Төсөөт ажлын тоо хэмжээг бүрэн авч тооцох, бусад холбогдох зардуудыг норм нормативын дагуу бүрэн гүйцэд тооцох, зураг төслийн үнийг хяналтын төсвийн дүнгээр төсөөт суулгаж тооцено.
24. Тухайн барилгын ажилд ашиглагдах цахилгааны тоног төхөөрөмж, бараа материалындаас ЗГ-ын 2019 оны 90-р тоогоолын хавсралтанд заасан барилгын материалын дотоодын үйлдвэрлэгчээс авч ашиглах, түүнийгээ нотлосон бичиг баримтыг ирүүлэх.

*Дээрхи бичиг баримтуудыг PDF хэлбэрт шилжүүлэн цахим хэлбэрээр ирүүлнэ. Харилцагч байгууллага, захиалагч ашиглагч нарын тодорхойлолт, албан бичиг, бичиг баримтуудыг эх хувиас ирүүлэх ба огноо нь тендер зарласан хугацаанд байна. Мэдээллүүдийг бүрэн ирүүлээгүй буюу худал мэдээлэл ирүүлсэн нөхцөлд тендерээс татгалзах үндэслэл болно.*

- |  |  |
|--|--|
| <p><b>4. Тендерийн үнэ</b></p>                       | <p>4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцгчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ. Үе шатны ажлын хуваарь нь ажил гүйцэтгэх хугацааны графиктай уялдсан байх шаардлагатай</p> <p>4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.</p> <p>4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.</p> <p>4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.</p> <p>4.5. Тендерт оролцгчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцгчийн албан мэдүүлэг ирүүлнэ.</p> |
| <p><b>5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b></p> | <p>5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p>  |
| <p><b>6. Алдааг залруулах</b></p>                    | <p>6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:</p> <p>(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;</p> <p>(б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;</p> <p>(в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох</p>   |

нэгж үнийг залруулна.

- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

## Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГДОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт																																							
ТОӨЗ 1.1	<p>1. 2019 онд төсөвт өртөгийн үнийн дүнгийн 100%-с багагүй хэмжээний ижил төстэй ажлуудыг хийж гүйцэтгэсэн туршлагатай байх. Гүйцэтгэсэн ажлын гэрээ, хүлээлгэн өгсөн актыг эх хувиас ирүүлэх. /Авто замын ажлыг тооцно/</p> <p>2. 2019 оны борлуулалтын орлого нь батлагдсан төсөвт өртөгийн үнийн дүнгээс багагүй байх</p> <p>3. Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: ЗТЯамны хайрган хучилттай зам барих тусгай зөвшөөрөлтэй байх ба гэрээг хамтад нь ирүүлнэ.</p> <p>4. Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th><th>Тоног төхөөрөмжийн нэр</th><th>Хүчин чадал</th><th>Тоо ширхэг</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1</td><td>Экскаватор</td><td>0,25 м3</td><td>1</td></tr> <tr> <td>2</td><td>Хүнд даацын индүү</td><td>10 тонн</td><td>1</td></tr> <tr> <td>3</td><td>Ачааны авто машин</td><td>10 тонн</td><td>1</td></tr> <tr> <td>4</td><td>Авто грейдер</td><td>105 м.х</td><td>1</td></tr> </tbody> </table> <p>Эдгээр техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийг бэлэн байгааг нотлох баримтыг фото зургийн хамт ирүүлнэ. Анхаарах: Гэрээт ажилд ашиглах машин механизмын, тоног төхөөрөмжийн гэрчилгээг эх хувиас, фото зургийн хамт ирүүлэх, Түрээсээр ашиглах бол зөвхөн орон нутгийн иргэд аж ахуйн нэгжтэй түрээсийн гэрээ хийж эх хувиас ирүүлнэ.</p> <p>5. Тендерт оролцогч нь ажлыг богино хугацаанд чанартай гүйцэтгэх дараах үндсэн ИТА-тай байна. Үүнд:</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th><th>Албан тушаал</th><th>Ажиллах хүчний тоо</th><th>Туршлага, ажилласан жил</th><th>Мэргэжил</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1</td><td>Талбайн инженер</td><td>1</td><td>5</td><td>Авто замын инженер</td></tr> <tr> <td>2</td><td>ХАБЭА-н ажилтан</td><td>1</td><td>2</td><td>Сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх</td></tr> </tbody> </table>	№	Тоног төхөөрөмжийн нэр	Хүчин чадал	Тоо ширхэг	1	Экскаватор	0,25 м3	1	2	Хүнд даацын индүү	10 тонн	1	3	Ачааны авто машин	10 тонн	1	4	Авто грейдер	105 м.х	1	№	Албан тушаал	Ажиллах хүчний тоо	Туршлага, ажилласан жил	Мэргэжил	1	Талбайн инженер	1	5	Авто замын инженер	2	ХАБЭА-н ажилтан	1	2	Сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх				
№	Тоног төхөөрөмжийн нэр	Хүчин чадал	Тоо ширхэг																																					
1	Экскаватор	0,25 м3	1																																					
2	Хүнд даацын индүү	10 тонн	1																																					
3	Ачааны авто машин	10 тонн	1																																					
4	Авто грейдер	105 м.х	1																																					
№	Албан тушаал	Ажиллах хүчний тоо	Туршлага, ажилласан жил	Мэргэжил																																				
1	Талбайн инженер	1	5	Авто замын инженер																																				
2	ХАБЭА-н ажилтан	1	2	Сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх																																				
ТОӨЗ 13.2	<p>Жич: Тендерт оролцогч нь ТББ-тэй бүрэн танилцсан байх шаардлагатай бөгөөд тендерийг цахим хэлбэрээр илгээхдээ бэлтгэсэн материалын товьёогын дагуу бүх файлыг /PDF/ файлаар ирүүлнэ.</p> <p>Тендерийн баримт бичгийг дутуу, товьёогийн дагуу бус болон PDF-ээс өөр файлаар ирүүлсэн тендерээс татгалзана.</p>																																							
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <b>2020 оны 06 дугаар сарын 19-ны өдөр</b>. Цаг: <b>08 цаг 30 минут</b></p> <p>Тендерийн материалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) хаягаар ААН-ийн хувийн тоон гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим (PDF) файл хэлбэрээр илгээнэ. Цахим систем ашиглан</p>																																							

Авто замын ажлын ТББ

	илгээх нийт файлын хэмжээ 100 Mb, нэг файлын хэмжээ 15 Mb байна. Мөн ТББ-т шаардсан баримт бичгүүдийн Эх хувиас скайнердаж ирүүлснийг ЭХ ХУВЬ гэж тооцох бөгөөд нотариатаар баталгаажуулсан баримт бичгийг эх хувьд тооцохгүй. Эх хувийг ямар нэгэн хэлбэрээр хуурамчаар үйлдсэн тохиолдолд тендерээс шууд татгалзаж, эрх бүхий байгууллагад хандаж “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл хамруулна
<b>ТОӨЗ 2.1</b>	Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: <b>Орхон аймгийн ЗДТГ, Нутгийн Удирдлагын ордон</b> Давхар болон өрөөний дугаар: <b>ЗДТГ-ын 1-р давхарт, Нэг цонхны үйлчилгээ, ХАА-ны сургалт, мэдээллийн танхим</b> Аймаг, хот: <b>Орхон аймаг</b> Улс: <b>Монгол Улс</b> Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: <b>2020 оны 06 дугаар сарын 19-ны өдөр</b> . Цаг: <b>09 цаг 00 минут</b>
<b>ТОӨЗ 2.3</b>	Тендерт оролцогчийн дараах бичиг баримтуудыг нээлттэй ил тод болгоно. <ul style="list-style-type: none"> <li>• Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ</li> <li>• Шүүхийн тодорхойлолт</li> <li>• Мэдэгдэл, албан бичгүүд</li> <li>• Ажил гүйцэтгэх хуваарь</li> <li>• Техник тоног төхөөрөмжийн чадавхийн мэдээлэл</li> <li>• Ажиллах хүчиний чадавхийн мэдээлэл</li> </ul> <p><i>Дээрх бичиг баримтуудыг тендерт оролцогч нарт нээлттэй үзүүлэхийг зөвшөөрсөн мэдэгдэл ирүүлэх.</i></p>
<b>ТОӨЗ 6.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>багцгүй</b>

## БАТЛАВ:

# ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Авто замын ажил, холбогдох инженерийн шугам сүлжээний ажлын явцад гүйцэтгэгч байгууллага ажлыг холбогдох норм дүрэм, стандарт, техникийн шаардлагад заасны дагуу чанарын гологдолгүй хийх бөгөөд **ажлын график төлөвлөгөө, технологийн аргачлалаа боловсруулж** ирүүлнэ.

Гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдээллийн самбарыг төв, суурин бүрийн олон нийтэд үзэгдэхүйц газар уг ажил, үйлчилгээний хугацаанд зайлшгүй байрлуулах шаардлагатай.

## **1.Замын ажилд тавигдах шаардлага**

а.Зам талбайн ажлыг гүйцэтгэхдээ ажлын зураг болон бусад холбогдох баримт бичгийн дагуу хийж гүйцэтгэнэ.

## **2. Замын хөдөлгөөн зохион байгуулалт, тоноглол тохижилт**

а.Зам барилгын ажлын үед шаардлагатай нэмэлт гарцуудыг холбогдох байгууллагуудтай зөвшилцэн нэмж гаргаж болох ба аливаа гарцыг гаргахдаа замын ус зайлцуулалтыг хангах, хөдөлгөөний аюулгүй байдал ба замын нэвтрүүлэх чадвар, тооцоот хурд хангалтыг бууруулахгүй байх нөхцлийг бурдуулсэн байна.

### **3.Зам барилгын ажилд тавигдах техникийн шаардлага**

Тус замын барилга угсралтын ажлыг гүйцэтгэхдээ ажлын зураг тус бүрийн техникийн шаардлага болон "Эрдэнэт хот, хот орчмын замын барилга, шинэчлэлт, их засварын ажлын техникийн шаардлага -д нийцуулэн гүйцэтгэнэ

БНБД 32.02.00 авто зам барих дүрмийн дагуу ажиллахдаа доорхи норм шаардлагуудыг хатуу барин ажиллах. Үүнд

а.БНБД 32.01.04 авто зам төлөвлөлтийн зорчих хэсгийн хучилтыг 21 бүлгийн 49-р зүйл, далангийн ажлыг 2-р бүлгийн 38-р зүйлийн дагуу, ногоон байгууламж, тусгаарлах зурвасыг 5-р бүлгийн дагуу, явган хүний зам, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын төлөвлөлтийг 3-р бүлгийн дагуу, газар доорхи инженерийн байгуулалтын төлөвлөлтийг 7-р бүлгийн дагуу, гудамж замын гадаргын ус зайлцуулах байгууламжийг 8-р бүлгийн дагуу, хотын гудамж талбайн гэрэлтүүлгийг 9-р бүлгийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Авто замын ажлын ТББ

б.Одоо байгаа борооны ус зайлцуулах хоолой болон худгийг ашиглагч байгууллагад гүйцэтгэгч актаар хүлээлгэн өгч ажил дууссаны дараа гүйцэтгэгч байгууллага ашиглагч байгууллагад мөн актаар хүлээлцэх, шинээр барих хоолой БнБД 33.06.09 -р гүйцэтгэнэ.

в.Зам талбайн ажлыг гүйцэтгэхдээ ажлын зураг болон бусад холбогдох баримт бичгийн дагуу хийж гүйцэтгэнэ. Ингэхдээ итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтийг үндэслэсэн чанартай шаардлага хангасан материалыг хэрэглэнэ.

#### 4.Тусгай шаардлага

Ажлын батлагдсан зураг төсөл болон холбогдох стандарт, норм, дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

Ажлын явцад гарсан хог хаягдлыг Хот тохижуулах газартай гэрээ байгуулан төвлөрсөн хогийн цэгт хаях ба ажил дууссаны дараа талбайг цэвэрлэж хүлээлгэн өгнэ.

Хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг хуульд заасны дагуу мөрдөж, түүнд шаардагдах хөрөнгийг хуулийн дагуу төлөвлөж, ажлын төсөвт багтааж, зарцуулах

Оршин суугчдын аюулгүй байдлыг бүрэн хангаж, ажлын байр, зам гарц, талбайг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу бэлтгэж, үйлдвэрлэлийг аюулгүй гүйцэтгэх нөхцлийг бүрэн хангах, хашаа хамгаалалтыг хийж оршин суугчдын зорчих хэсгийг гаргаж анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг хийх. Ажилтнууд хамгаалах хэрэгслэлээр бүрэн хангагдсан байна.

Гүйцэтгэгч нь ашиглагч, хангагч байгууллагуудтай уялдаатай ажиллана.

Ажлыг гүйцэтгэх үед нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт, инженерийн шугам, зогсоол, явган зам, холбоо, цахилгаан, интернетийн кабель утсыг гэмтээсэн тохиолдолд гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр түргэн шуурхай засварлан хангагч байгууллагад хүлээлгэн өгнэ.

Гүйцэтгэгч нь хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрэн хангах, үүнээс гарах хор хохирлыг өөрсдөө хариуцна. Байгалийн гэнэтийн гамшиг, гал түймэр, үер усны гамшигаас сэргийлэн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллана.

Гэрээнд тусгайлан заагаагүй тохиолдолд тендерийн саналын үнэлсэн ажлын тоо хэмжээнд тусгагдсан үнэлгээ болон үнэ нь гэрэлтүүлгийн ажлыг явуулахад шаардагдах тоног төхөөрөмж, хүн хүч хяналт, материал, ашиг татвар хураамж болон гэрээний хүрээнд хүлээх ёстой үүрэг хариуцлагыг хамруулсан байна.

Ажлын тоо хэмжээнд тодорхойлсон магадлашгүй ажлын зардлыг зарцуулахад захиалагчийн зөвшөөрөл баталгааг авна

Тендерийн нийт үнэд НӨТ, нормчлолын сангийн шимтгэл, дараах зураг төсвийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, магадлашгүй ажлын зардлыг төсөвт тусгаж өгнэ

Гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдэллийн самбарыг төв, суурин бүрийн олон нийтэд үзэгдэхүйц газар уг ажил, үйлчилгээний хугацаанд зайлшгүй байрлуулах шаардлагатай. /Ажлын гүйцэтгэлийн явцад тулган баталгаажуулна./ Ажлыг гүйцэтгэх технологийн аргачлал, каленъдарчилсан төлөвлөгөөний дагуу хугацаанд нь чанарын гологдолгүй ажиллахад анхаарах хэрэгтэй

Ажлын зураг, тоо хэмжээг хавсаргав:

**Тав. ЗУРАГ**

**Зургийн санамж**

**Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ**

**Ажил гүйцэтгэх график ирүүлэх**

**Долоо. ЖИШИГ МАЯГТ**

**ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| <p>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</p> <p>2. Төслийн менежерийн шийдвэр</p> <p>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</p> <p>4. Аюулгүй байдал</p> <p>5. Зааварчилгаа</p> <p>6. Маргааныг шийдвэрлэх</p> <p>7. Ажлын хөтөлбөр</p> <p>8. Зөрчил, гологдол илрүүлэх</p> | <p>1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.</p> <p>2.1. Гэрээнд тусгайллан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.</p> <p>3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.</p> <p>4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.</p> <p>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.</p> <p>5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй</p> <p>6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.</p> <p>7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.</p> <p>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн Үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.</p> <p>8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдолын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.</p> |
|--|---|

- |   |  |
|---|--|
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>          | <p>9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа<sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.</p> <p>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.</p> |
| <b>10. Зөрчил, гологдол арилгахгүй байх</b> | <p>10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардлагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.</p>  |

## B. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- |   |  |
|---|--|
| <b>11. Үе шатны ажлын хуваарь</b>           | <p>11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.</p> <p>11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.</p> |
| <b>12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх</b> | <p>12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.</p>   |
| <b>13. Алданги</b>                          | <p>13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.</p>                                 |

## Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- |                         |  |
|-------------------------|--|
| <b>14. Ажил дуусгах</b> | <p>14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.</p> |
| <b>15. Хүлээж авах</b>  | <p>15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.</p>  |

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.  
Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хулээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.  
Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гарана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгаагаар гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль

болов түргэн хугацаанд чөлөөлнө.

- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоноо. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ec. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>3</sup>

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: [Дэнж багийн 20-р цэцэрлэгийн арын сайжруулсан шороон замын засвар], ОР-55/2020
<b>ГЕН 2.1</b>	Ажил нь [Дэнж багийн 20-р цэцэрлэгийн арын сайжруулсан шороон замын засвар]- ажлаас бүрдэнэ.  Ажлын талбай нь [байршил]-д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь [томилогдсон этгээдийн нэр, хаяг]
<b>ГЕН 4.1</b>	Ажил эхлэх өдөр [2020-06-30]  Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр [2020-07-30] <sup>4</sup>
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш [7] хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа [365] хоног байна.
<b>ГЕН 13.1</b>	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн [0,5 хувь] байна. <sup>5</sup>  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн [5 хувь] байна.
<b>ГЕН 17.1</b>	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг [2020-07-30]-ны дотор гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг [2020-07-30]-ны дотор гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ [мөнгөн дүн] байна.
<b>ГЕН 19.1</b>	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын [100 хувь]-иар тооцно.

<sup>3</sup> Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна.  
Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

<sup>4</sup> Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

<sup>5</sup> Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хүчинтэй, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт

Авто замын ажлын ТББ

\_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.
8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]